



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/106/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас:70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн Аудитор: С.Батсайхан Утас: 88171516, Цахим хаяг: shurtkhairkhaniikhishigaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв	11
2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1.Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 .Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ДАВСТ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
О.БОЛОРТУЛГА ТАНАА

2026.02.05 № УВА-2026/106/НА-СТА-ТЦЗ.
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050122

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	98,459,351.10	153,692,131.57
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,490,128.98	16,494,131.95
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,490,128.98	16,494,131.95
3121	Төгрөг	5,490,128.98	16,494,131.95
31211	Төрийн сангийн харилцах	5,490,128.98	16,494,131.95
33	АВЛАГА	47,774,526.82	50,427,743.75
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	44,119,429.52	50,427,743.75
335	Бусад авлага	3,655,097.30	00.00
3351	Байгууллагаас авах авлага	3,655,097.30	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,194,695.30	86,770,255.87
351	Түүхий эд материал	22,582,763.30	29,434,583.87
35130	Эм боох материал	22,582,763.30	29,434,583.87
354	Хангамжийн материал	22,611,932.00	57,335,672.00
35410	Бичиг хэргийн материал	3,339,200.00	3,687,600.00
35420	Аж ахуйн материал	18,369,852.00	26,952,552.00
35460	Хүнсний материал	902,880.00	4,940,810.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	21,754,710.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	714,203,675.63	2,177,743,347.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	714,203,675.63	2,177,743,347.17
392	Биет хөрөнгө	705,633,586.68	2,169,188,258.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	460,401,213.00	1,951,122,293.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-82,481,544.70	-114,596,964.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	186,925,545.00	186,925,545.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-83,025,387.73	-103,129,942.21
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	400,754,709.63	458,162,757.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-197,376,723.25	-239,514,905.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,276,289.32	86,059,989.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-55,940,514.59	-55,940,514.59
39217	Ном	100,000.00	100,000.00
393	Биет бус хөрөнгө	8,570,088.95	8,555,088.95
39303	Бусад биет бус хөрөнгө	9,804,000.00	9,804,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,233,911.05	-1,248,911.05
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	812,663,026.73	2,331,435,478.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,238,828.00	12,218,702.39
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,238,828.00	12,218,702.39
413	Өглөг	18,238,828.00	12,218,702.39
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	4,386,299.39
4136	Бусад өглөг	18,238,828.00	7,832,403.00
41361	Байгууллагад төлөх өглөг	17,706,828.00	6,733,303.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	532,000.00	1,099,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	794,424,198.73	2,319,216,776.35
51	Засгийн газрын хувь оролцоо	794,424,198.73	2,319,216,776.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	456,148,700.71	456,148,700.71
51101	Өмч: - төрийн	456,148,700.71	456,148,700.71
512	Хуримтлагдсан үр дүн	290,256,458.28	1,815,049,035.90
51210	Өмнөх үеийн үр дүн	290,256,458.28	290,256,458.28

**Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,524,792,577.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	48,019,039.74	48,019,039.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	812,663,026.73	2,331,435,478.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	900,239,931.60	2,463,398,485.28
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,003,122.00	1,589,279,193.08
120	Нийтлэг татварын бус орлого	85,003,122.00	1,589,279,193.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,370,000.00	12,001,854.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,370,000.00	9,801,854.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	815,236,809.60	874,119,292.20
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,476,900.00	53,073,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,476,900.00	53,073,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	753,759,909.60	821,046,192.20
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	753,759,909.60	821,046,192.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	883,724,012.00	938,605,907.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	883,724,012.00	938,605,907.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,307,537.00	938,605,879.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	529,504,024.10	593,298,473.49
210101	Үндсэн цалин	356,161,925.63	499,251,445.49
210102	Нэмэгдэл	169,560,098.47	94,047,028.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,782,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,522,573.87	73,109,323.20
210201	Тэтгэврийн даатгал	42,625,193.23	50,202,774.26
210202	Тэтгэмжийн даатгал	5,357,100.00	5,360,311.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,678,500.00	2,924,372.86
210204	Ажилгүйдлийн даатгал	2,864,800.00	2,924,372.86
210205	Эрүүл мэндийн даатгал	12,996,980.64	11,697,491.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,560,425.00	55,250,426.59
210301	Гэрэл, цахилгаан	4,971,605.09	2,953,130.58
210302	Түлш, халаалт	52,007,419.91	52,007,296.01
210303	Цэвэр, бохир ус	1,581,400.00	290,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,915,650.00	40,812,650.00
210401	Бичиг хэрэг	4,556,100.00	3,172,200.00
210402	Тээвэр, шатахуун	31,337,350.00	25,602,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,002,000.00	1,536,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	933,200.00	3,390,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,087,000.00	7,111,150.00
2105	Нормативт зардал	99,849,414.02	58,429,600.43

**Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83,669,005.02	48,340,605.43
210502	Хоол, хүнс	16,180,409.00	10,088,995.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,840,000.00	8,631,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	00.00
210604	Урсгал засвар	4,760,000.00	8,631,100.00
2107	Томилолт, зочны зардал	3,540,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,540,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,159,556.00	10,701,149.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,617,500.00	8,477,129.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	332,314.00	107,620.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,033,500.00	1,010,000.00
210807	Газрын төлбөр	42,292.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,415,894.01	94,373,156.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,475,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,940,894.01	94,373,156.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	416,475.00	28.39
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	416,475.00	28.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	416,475.00	28.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	16,515,919.60	1,524,792,577.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,574,999.88	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,574,999.88	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,574,999.88	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,940,919.72	1,524,792,577.62

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	793,726,450.08	870,010,977.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,370,000.00	2,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,370,000.00	2,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,370,000.00	2,200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,370,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	784,356,450.08	867,810,977.97
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,476,900.00	53,073,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,476,900.00	53,073,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	722,879,550.08	814,737,877.97
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	722,879,550.08	814,737,877.97
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	786,739,717.07	857,164,475.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	786,739,717.07	857,164,475.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	786,323,242.07	857,164,446.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,137,229.06	584,818,500.00
210101	Үндсэн цалин	326,119,822.59	338,394,406.30
210102	Нэмэгдэл	210,235,406.47	214,211,993.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,782,000.00	6,716,400.00
210104	Урамшуулал	00.00	25,495,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,950,338.99	72,887,900.00
210201	Тэтгэврийн даатгал	45,031,838.99	49,015,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,729,600.00	5,968,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,864,800.00	2,983,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,864,800.00	2,983,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,459,300.00	11,936,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,560,425.00	45,513,071.61
210301	Гэрэл, цахилгаан	4,971,605.09	2,953,130.58
210302	Түлш, халаалт	52,007,419.91	42,205,441.03
210303	Цэвэр, бохир ус	1,581,400.00	354,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,773,800.00	50,861,750.00
210401	Бичиг хэрэг	4,974,600.00	3,016,500.00
210402	Тээвэр, шатахуун	25,995,900.00	30,943,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,002,000.00	1,536,500.00

**Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,090,300.00	6,304,551.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,711,000.00	9,060,749.00
2105	Нормативт зардал	69,378,107.02	83,746,265.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,567,042.02	64,414,866.00
210502	Хоол, хүнс	13,203,565.00	16,010,399.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,607,500.00	3,321,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,480,100.00	10,147,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	65,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	80,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	3,335,100.00	10,067,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,130,000.00	4,000,000.00
210702	Дотоод албан томилолт	4,130,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,927,242.00	5,189,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,617,500.00	3,033,260.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,033,500.00	1,010,000.00
210807	Газрын төлбөр	42,292.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,986,000.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,986,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	416,475.00	28.39
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	416,475.00	28.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	416,475.00	28.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,986,733.01	12,846,502.97
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,835,000.00	1,842,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,835,000.00	1,842,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,835,000.00	1,842,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,835,000.00	1,842,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,835,000.00	-1,842,500.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,151,733.01	11,004,002.97
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,338,395.97	5,490,128.98
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,490,128.98	16,494,131.95

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	497,263,451.26	50,203,569.98	247,665,248.01	795,132,269.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	497,263,451.26	50,203,569.98	247,665,248.01	795,132,269.25
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-16,683,915.69	-16,683,915.69
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	456,148,700.71	48,019,039.74	290,256,458.28	794,424,198.73
9	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	456,148,700.71	48,019,039.74	290,256,458.28	794,424,198.73
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	456,148,700.71	48,019,039.74	290,256,458.28	794,424,198.73
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
16	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,524,792,577.62	1,524,792,577.62
17	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	456,148,700.71	48,019,039.74	1,815,049,035.90	2,319,216,776.35

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	843,910,000.00	805,933,875.00	37,976,125.00	95.50
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	843,910,000.00	805,933,875.00	37,976,125.00	95.50
4	Бараа, үйлчилгээний зардал	843,910,000.00	805,933,875.00	37,976,125.00	95.50
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	587,904,000.00	584,818,500.00	3,085,500.00	99.48
6	Үндсэн цалин	416,010,700.00	338,394,406.30	77,616,293.70	81.34
7	Нэмэгдэл	139,681,200.00	214,211,993.70	(74,530,793.70)	153.36
8	Унаа, болон бусад нөхөн олговор	6,716,400.00	6,716,400.00	-	100.00
9	Урамшуулал	25,495,700.00	25,495,700.00	-	100.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,061,300.00	72,887,900.00	173,400.00	99.76
12	Тэтгэврийн даатгал	49,133,300.00	49,015,500.00	117,800.00	99.76
13	Тэтгэмжийн даатгал	5,982,000.00	5,968,500.00	13,500.00	99.77
14	ҮОМШӨ ний даатгал	2,991,000.00	2,983,900.00	7,100.00	99.76
15	Ажилгүйдлийн даатгал	2,991,000.00	2,983,900.00	7,100.00	99.76
16	Эрүүл мэндийн даатгал	11,964,000.00	11,936,100.00	27,900.00	99.77
22	Хангамж, бараа материалын зардал	59,589,400.00	50,861,750.00	8,727,650.00	85.35
23	Бичиг хэрэг	5,085,000.00	3,016,500.00	2,068,500.00	59.32
24	Тээвэр (шатахуун)	39,064,200.00	30,943,450.00	8,120,750.00	79.21
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,706,200.00	1,536,500.00	169,700.00	90.05
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,534,000.00	6,304,551.00	(1,770,551.00)	139.05
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	9,200,000.00	9,060,749.00	139,251.00	98.49
30	Нормативт зардал	96,102,200.00	83,746,265.00	12,355,935.00	87.14
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	73,475,500.00	64,414,866.00	9,060,634.00	87.67
32	Хоол, хүнс	16,101,700.00	16,010,399.00	91,301.00	99.43
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	6,525,000.00	3,321,000.00	3,204,000.00	50.90
34	Эд хогшил худалдан авах	7,180,000.00	4,429,800.00	2,750,200.00	61.70

**Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

35	Багаж, техник, хэрэгсэл	4,700,000.00	1,842,500.00	2,857,500.00	39.20
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	80,000.00	80,000.00	-	100.00
38	Урсгал засвар	2,400,000.00	2,507,300.00	(107,300.00)	104.47
39	Томилолт, зочны зардал	6,070,200.00	4,000,000.00	2,070,200.00	65.90
41	Дотоод албан томилолт	6,070,200.00	4,000,000.00	2,070,200.00	65.90
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	12,562,000.00	5,189,660.00	7,372,340.00	41.31
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,233,600.00	3,033,260.00	7,200,340.00	29.64
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	806,400.00	806,400.00	-	100.00
46	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00	-	100.00
47	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	40,000.00	60,000.00	40.00
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	-	88,000.00	-
49	Мэдээллийн технологийн зардал	1,034,000.00	1,010,000.00	24,000.00	97.68
50	Газрын төлбөр	100,000.00	100,000.00	-	100.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	1,440,900.00	-	1,440,900.00	-
54	Бараа үйлчилгээний бусад зардал	1,440,900.00	-	1,440,900.00	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	824,529,800.00	800,443,846.02	24,085,953.98	97.08
106	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	822,329,800.00	798,243,846.02	24,085,953.98	97.07
108	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	822,329,800.00	798,243,846.02	24,085,953.98	97.07
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,200,000.00	2,200,000.00	-	100.00
111	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,200,000.00	2,200,000.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,490,128.98	(5,490,128.98)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	16,494,131.95	(16,494,131.95)	-

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,073,200.0	53,073,071.61	128.39	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	53,073,200.0	53,073,071.61	128.39	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,073,200.0	53,073,071.61	128.39	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,513,200.0	45,513,043.21	128.39	100%
210301	Гэрэл, цахилгаан	11,338,000.0	2,953,130.6	8,384,869.4	26%
210302	Түлш, халаалт	30,593,200.0	42,205,441.0	-11,612,241.0	138%
210303	Цэвэр бохир ус	3,582,000.0	354,500.0	3,581,673.89	9.9%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,560,000.0	7,560,000.0	0.0	100%
210604	Урсгал засвар	7,560,000.0	7,560,000.0	0.0	100%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	53,073,200.0	53,073,071.61	128.39	100%
320001	Орон нутгийн төсвөөс	53,073,200.0	53,073,071.61	128.39	100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Давст сумын Эрүүл мэндийн төв нь хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд байршил, хүн амын төвлөрөл, өвчлөл, осол гэмтлийн нөхцөл байдлаас хамааран яаралтай тусламж, үйлчилгээний болон багийн эмчийн салбартай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,518,772.5 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,490.1	16,494.1	11,004.0
Авлага	47,774.5	50,427.7	2,653.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	45,194.7	86,770.3	41,575.6
Үндсэн хөрөнгө	714,203.7	2,177,743.3	1,463,539.7
Нийт хөрөнгө	812,663.0	2,331,435.5	1,518,772.5
Өр төлбөр	18,238.8	12,218.7	(6,020.1)
Засгийн газрын хувь оролцоо	794,424.2	2,319,216.8	1,524,792.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	812,663.0	2,331,435.5	1,518,772.5

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын хувь оролцоо, өр төлбөрийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 16,494.1 мянган төгрөг болж, 11,004.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийг хэмнэж ажилласантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 50,427.7 мянган төгрөг болж, 2,653.2 мянган төгрөгөөр өссөн нь төлбөртэй үйлчилгээний авлага 2,653.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 86,770.3 мянган төгрөг болж, 41,575.6 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 6,851.8 мянга, бичиг хэргийн материал 348.4 мянга, аж ахуйн материал 8,582.7 мянга, хүнсний материал 4,037.9 мянга, бусад хангамжийн материал 21,754.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,177,743.3 мянган төгрөг болж, 1,463,539.7 мянган төгрөгөөр өссөн нь барилга, байгууламж орон сууц 1,490,721.1 мянга, машин тоног төхөөрөмж 57,408.0 мянга, тавилга эд хогшил 9,783.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн, тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл 94,373.1 мянган төгрөгийн зардал гарсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 12,218.7 мянган төгрөг болж, 6,020.1 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өглөг 10,973.5 мянган төгрөгөөр буурч, хувь хүмүүст төлөх өглөг 567.1 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 618.1 мянга, ХАОАТ-ын өглөг 3,768.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,319,216.8 мянган төгрөг болж, 1,524,792.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,120,634.6 мянга, орон нутгийн төсвөөс 63,993.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 298,304.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 10,919.8 мянган төгрөгөөр баталжээ.

Дээрх баталсан төсвөөс санхүүжилтийг бүрэн олгосон ба төсвийн гүйцэтгэлээр тайлант онд орон нутгийн төсөвт 28.39 төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн хүрээнд 40 арга хэмжээнд улсын төсвөөс 822,329.8 мянга, орон нутгийн төсвөөс 53,073.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 798,234.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,200.0 мянга, орон нутгийн төсвөөс 53,073.1 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлжээ.

Улсын төсвийн зардлын гүйцэтгэл 805,933.9 мянган төгрөг буюу 97.6 хувьтай, орон нутгийн төсвийн гүйцэтгэл 53,073.1 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /Улсын төсөв/ /мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	80302	Нэг иргэнд ногдох нормативаар	558,011.2	558,011.2	0.0	100%
2	81603	Үндсэн мэргэжлийн тусламж үйлч	226,809.4	200,870.8	25,938.6	88.5%
3	83603	Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	59,089.4	47,051.9	12,037.5	79.6%
		ДҮН	843,910.0	805,933.9	37,976.1	95.5%

**Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / Орон нутгийн төсөв/

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	биелэлтийн хувь
	Код	НЭР				
1	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	53,073.2	53,073.1	0.028	100
			53,073.2	53,073.1	0.028	100

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл, тайлагнал	0.0	0.0	Тайлант онд программы хангамж худалдан аваагүй байна.
2	Унаа хоолны хөнгөлөлт, зардлын тариф	6,716.4	6,716.4	Дотоод журамд заасны дагуу нэг хүнд 1 өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	0.0	0.0	Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зардал гараагүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	0.0	0.0	Тайлант онд гадаад томилолтод зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	0.0	0.0	Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	0.0	0.0	Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудад төлбөр төлөөгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Давст сумын Эрүүл мэндийн төвийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Давст сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд 125,126.8 мянган төгрөгийн бараа материалын шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн аудитор С.Батсайхан гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шүрт хайрханы хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 938,605.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,386.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг төлөвлөлтийн 80.0 хувиар буюу 7,508.8 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Давст сумын Эрүүл мэндийн төв нь тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

УВА-2026/106/НА-СТА-ТШЗ

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Давст сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 48 мэдээллээс хугацаандаа оруулсан 37, хугацаа хоцорч оруулсан 9 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс

**Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн										

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ" ХХК-ийн АУДИТОР  /С.БАТСАЙХАН/



2026 оны 02 дугаар сарын 5-ны өдөр